

# **Харриет Фулбрайт Коллежийн** **хөтөлбөрүүд**

## **ХФК-ийн Англи хэлний эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөр**

Үндсэн хөтөлбөр

Гүнзгий шатны сонгон суралцах хөтөлбөрүүд

Хэл зүйн дүрэм

Зөв бичгийн дүрэм

## **ХФК-ийн ганцаарчилсан хөтөлбөрүүд**

Сургалтын хотхонд болон гадуур

Зайн сургалт

Дүлий, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн сургалт

## **ХФК-ийн шалгалтанд бэлтгэх сургалт**

TOEFL - Англи хэлний түвшин тогтоох шалгалт

SAT – Ерөнхий мэдлэгийн шалгалт

GRE – Аспирант, магистрантуруудад зориулсан хэлний шалгалт

GMAT – Удирдлагын ур чадварын шалгах ерөнхий шалгалт

## **ХФК-ийн сертификатын хөтөлбөрүүд**

Бизнесийн Англи хэл

Хууль зүйн Англи хэл

Эмнэлгийн Англи хэл

## **ХФК-ийн зуны сургуулийн хөтөлбөр**

## **ХФК-ийн Англи хэлний эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөр**

### **Хөтөлбөрийн агуулга**

ХФК-ийн Англи хэлний эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөр нь манай үндсэн хөтөлбөрийн арван хоёр түвшний сургалт, гүнзгий шатны сонгон суралцах таван курс, хэл зүйн дүрмийн хоёр курс, зөв бичгийн дүрмийн нэг курсээс бүрдэнэ. Үндсэн хөтөлбөр Англи хэлний унших, бичих, сонсох ба ярих чадварын хүрээнд анхан шатнаас авахуулаад гүнзгийрүүлсэн академик түвшний сургалтуудаас бүрддэг. Сонгон суралцах курсууд нь Англи хэлний мэдлэгийг дээшлүүлж, чөлөөтэй харьцаж сурах, Америкийн соёлтой илүү сайн танилцахад нь оюутнуудад тусалдаг. Хэл зүйн дүрмийн сургалтууд нь Англи хэлний хэл зүйн дүрмийг бүхэлд нь хамардаг бол зөв бичгийн дүрмийн сургалтууд нь Англи үсгийн цагаан толгой ашиглан Англи хэлээр гарамгай уншиж, бичиж сурахад зориулагдсан болно.

Эдгээр сургалтууд нь Англи хэлийг ерөнхий хүрээнд хамарсан тул амжилттай дүүргэх нь Америкийн Англи хэлийг төгс эзэмшсэний илэрхийлэл байх болно. Оюутнууд түвшнээ ахиулж суралцсанаар өөрсдийн ур чадвараа хөгжүүлж, илүү хүнд хэцүү даалгавар, шалгалтуудыг давсны эцэст дүрмийн дагуу зөв бөгөөд чөлөөтэй ярих, Англи хэлний ярианы албан ёсны болон хэвшмэл үг хэллэгийг төвөггүй ойлгож, их дээд сургуулийн түвшинд унших, эссе бичих ур чадвартай болно.

### **Сургалтын материалууд**

Харриет Фулбрайт Коллеж нь Англи хэлний эрчимжүүлсэн сургалтандаа орчин үеийн, харилцан ярианд тулгуурласан сурах бичгүүдийг ашигладаг. Англи хэлний эрчимжүүлсэн сургалтын үндсэн хөтөлбөр нь мэдлэгийн нэг түвшнээс дараагийн түвшин рүү хялбар байдлаар ахих боломжийг олгодог цуврал сурах бичгүүдийг ашигладаг. Гүнзгий шатны сонгон суралцах курсууд нь хэлц үг хэллэг, мэтгэлцэх, бичих ба Америк соёл гэх мэт тодорхой чадвар болон элементүүд дээр голлон анхаарсан сурах бичгүүд дээр тулгуурладаг.

Манай Англи хэлний эрчимжүүлсэн бүх сургалтууд олон янзын баталгаатай мэдээллийн эх үүсвэр болон сэтгэн бодох дасгалуудыг ашигладаг. Энэхүү арга зүй нь оюутнуудыг Англи хэлний өөр өөр эх сурвалжтай тулгаруулж, Англи хэлээр зөвхөн ярих бус харин Англи хэл дээр сэтгэн бодоход сургадаг. Ингэснээр оюутнууд Англи хэлийг чөлөөтэй эзэмшихэд шаардагдах бүх чадварыг хөгжүүлж чаддаг. Үүний зэрэгцээ багш нар хичээлээ баяжуулахын тулд тухайн хичээлтэй холбогдолтой сонин сэтгүүл, видео ба аудио бичлэгүүд, бусад төрлийн мэдээллийн хэрэгсэл гэх мэт янз бүрийн материалыг ашигладаг. Вашингтоны дурсгалт газрууд руу хийх аялалууд нь оюутнуудад шинэ зүйл сурах, эзэмшсэн хэлний ур чадвараа бодит амьдралд хэрэгжүүлэх боломжийг олгодог.

## **Багш нар**

ХФК-ийн багш нар боловсрол, Англи уран зохиол, гадаад хүмүүст Англи хэл заах (TESOL) чиглэлээр ахиу шатны зэрэг хамгаалсан, өндөр мэдлэг боловсролтой мэргэжлийн багш нар байдаг. Үүн дээр нэмж дурдахад манай олон багш нар дотоод болон гадаадад олон арван жилээр багшилсан туршлагатай хүмүүс байдаг. ХФК нь багш нараа хамгийн сүүлийн үеийн заах арга барилд тасралтгүй сургах зорилгоор мэргэжлийн чадварыг дээшлүүлэх семинаруудыг тогтмол зохион байгуулдаг. Хичээлийн явцад оюутнуудтай харилцах харилцаа нь утга төгөлдөр харилцаанд тулгуурладаг бөгөөд оюутны хэлний чадварыг бодитоор хөгжүүлэхийг чухалчилдаг.

Сургалтын үргэлжлэх хугацаа: 4 долоо хоног

Хичээлийн цаг: Даваа-Баасан гаригт 9:00-12:50 цагийн хооронд эсвэл Даваа-Пүрэв гаригт 17:30-22:00 цагийн хооронд

Бүртгэлийн хураамж:	\$ 60
Сургалтын төлбөр:	\$750 өглөөний анги
	\$550 оройн анги

## **ХФК-ийн ганцаарчилсан хөтөлбөрүүд**

### **Хичээлийн танхимд болон гадуур**

Энд жагсаасан бүх сургалтыг тохируулах боломжтой бөгөөд ганцаарчилсан сургалтаар хамрагдах боломжтой. Эдгээр ганцаарчилсан сургалтыг хичээлийн танхимд эсвэл тухайн оюутны сонгосон газар явуулах боломжтой. Оюутнууд эдгээр сургалтанд долоо хоногийн аль ч үед хамрагдах боломжтой. Сургалтын төлбөрийг цагаар үнэлсэн болно.

Нэг цагийн үнэ (9:00-14:00 цагийн хооронд)	\$45
Нэг цагийн үнэ (14:00-22:00 цагийн хооронд)	\$43
Шалгалтанд бэлтгэх цагийн үнэ:	\$50

### **Зайн сургалт**

Англи хэлний сургалтанд өөрийнхөө гэрийн тав тухтай орчинд хамрагдах боломжтой. Манай чадварлаг багш нар Интернетээр дамжуулан хичээл зааж, амжилтанд хүрэхэд шаардагдах ур чадварыг тань дээшлүүлж өгөх болно. Эдгээр нь ганцаарчилсан сургалтууд бөгөөд тухайн оюутны хэрэгцээ шаардлагад тусгайлан нийцүүлсэн болно. Таны цагийн хуваарьт нийцсэн богино эсвэл урт хугацааны, түвшин бүрт зориулагдсан эсвэл чадварт голлож анхаарсан сургалтуудыг санал болгож байна.

Оюутны мэдлэгийн анхны үнэлгээ Унших, бичих, ярих, сонсох

- Ерөнхий ба Академик Англи хэл
- Мэргэжлийн ба Бизнесийн Англи хэл
- Шалгалтанд бэлтгэх (TOEFL, IELTS, GRE, GMAT)

Багш нар гэрийн даалгавар, тестүүд болон шалгалтуудыг имэйлээр өгч, мөн оюутны сургалтын явцын тайлангуудыг өгдөг.

## **Дүлий болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан Англи хэлний сургалт**

Харриет Фулбрайт Коллеж нь дүлий болон сонсголын бэрхшээлтэй оюутнуудад зориулж Англи хэлийг хоёрдогч хэл болгон сурах (ESL) өвөрмөц хөтөлбөрийг санал болгож байгаадаа баяртай байна. Эдгээр сургалтууд нь F1 визтэй оюутнуудад зориулагдсан бөгөөд тусгай шаардлагад тохируулсан богино хугацааны эсвэл эрчимжүүлсэн сургалтын хэлбэртэй байдаг.

Дүлий болон сонсголын бэрхшээлтэй хүмүүс зориулагдсан ESL хөтөлбөрийг Харриет Фулбрайт Коллежийн хэвийн сонсголтой оюутнуудад зориулагдсан Англи хэлний унших ба бичиж сурах сургалтын агуулга болон стандартуудын дагуу явуулдаг.

- Анхан шатнаас гүнзгийрүүлсэн шат хүртэл бүх түвшин
- Ерөнхий ба Академик Англи хэл
- Мэргэжлийн ба Бизнесийн Англи хэл
- Шалгалтанд бэлтгэх сургалт (TOEFL, IELTS, GRE, GMAT)

Хөтөлбөрийн багш нар маань дүлий эсвэл сонсголын бэрхшээлтэй оюутнуудад ESL заах өргөн мэдлэг, арга барил, туршлагатай бөгөөд Америкийн дохио зангааны хэлийг бүрэн эзэмшсэн байдаг. Манай сургалтууд харилцан ярианд бүрэн тулгуурладаг бөгөөд хамгийн сүүлийн үеийн, амжилттай туршигдсан арга барилыг ашигладаг. Бид ганцаарчилсан болон жижиг группээр хичээллэх сургалтыг санал болгодог.

## **ХФК-ийн шалгалтанд бэлтгэх сургалтууд**

ХФК-ийн шалгалтанд бэлтгэх сургалтууд нь оюутнуудыг стандартчлагдсан тестүүдэд өндөр оноо авах туршлага болон бэлтгэлтэй болгож өгдөг. ХФК нь TOEFL, SAT, GRE, мөн GMAT шалгалтанд бэлтгэх сургалтуудыг санал болгодог. Шалгалтанд бэлтгэх сургалтуудын багш нар маань шалгалтанд бэлтгэх арга барилыг зааварчлах өргөн туршлагатай мэргэжлийн хүмүүс байдаг.

### **TOEFL**

Англи хэлний түвшин тогтоох шалгалт нь тухайн хүний Англи хэлийг ашиглах, мөн ойлгох чадварыг үнэлж тогтоодог. Мөн, их, дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хамрагдах гэж буй гадаад оюутнуудад тавигддаг элсэлтийн шаардлага нь байдаг. Харриет Фулбрайтын Коллеж нь дараахь хоёр сургалтын хувилбарыг санал болгодог. Үүнд, Өглөөний ба оройн сургалтын хөтөлбөр. Сургалтыг дүүргэсний дараа оюутнууд байнга ашиглагддаг үгсийн сангийн жагсаалтууд болон эссений өгөгдлүүд гэх мэт TOEFL шалгалтын талаар бүрэн ойлголттой болсон байна.

### **SAT – Ерөнхий мэдлэгийн шалгалт**

SAT Сэтгэхүйн ерөнхий чадварын шалгалт нь коллежийн элсэлтийн стандартчлагдсан тест юм. Энэ сургалтанд хамрагдсанаар тест өгөх чадвартай болохын хажуугаар математик, унших, бичих, үгсийн сангийн мэдлэгийг олж авдаг. Шууд зааврын дараа ганцаарчилсан дадлага болон тухайн ангийг бүхэлд нь хамарч хариултуудыг хянадаг. Мөн, хариултуудын хяналтыг заах хэрэгсэл болгоход ашигладаг. Буруу хариулсан асуултуудыг нарийвчилсан байдлаар задалж үзэх нь гүйцэтгэлийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

### **GRE – Аспирант, магистрантуудад зориулсан шалгалт**

GRE шалгалт нь Америкийн их дээд сургууль болон коллежийн магистрантур, аспирантурын хөтөлбөрт хамрагдахад заавал өгөх ёстой стандартчлагдсан элсэлтийн шалгалт юм. ХФК-ийн GRE шалгалтанд бэлтгэх сургалт нь 4 долоо хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд оюутнууд шалгалт өгөхөд шаардагдах чадвартай болж, өөрсдийн математик, унших, бичих болон үгсийн сангийн агуулгын мэдлэгээ сайжруулдаг.

Сургалтын хугацаанд оюутнууд GRE шалгалтыг дөрвөн загвараар өгдөг. Эдгээр шалгалтуудыг онлайнгаар өгдөг. Эхний шалгалт нь Оношлох шалгалтын үүргийг гүйцэтгэдэг. Оношлох шалгалтыг хичээлийн эхний өдөр авдаг. Дадлагын дөрөвдэх шалгалтыг хичээлийн сүүлчийн өдөр хичээлийн танхимд авдаг. Дадлагын дөрөвдэх шалгалт нь эцсийн шалгалт байдаг.

## **GMAT – Удирдлагын ур чадварын шалгах ерөнхий шалгалт**

МВА хөтөлбөрт хамрагдах гэж буй бүх оюутнуудаас Удирдлагын ур чадварыг шалгах ерөнхий шалгалт (GMAT) өгсөн байхыг шаарддаг. ХФК-ийн GRE шалгалтанд бэлтгэх сургалт нь 4 долоо хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд оюутнууд шалгалт өгөхөд шаардагдах ур чадвартай болж, өөрсдийн математик, унших, бичих болон үгсийн сангийн агуулгын мэдлэгээ сайжруулдаг.

Сургалтын хугацаанд оюутнууд GMAT шалгалтыг гурван загвараар өгдөг. Эдгээрийн нэг нь бичгийн хэлбэрээр цаасан дээр өгдөг ба үлдэх хоёрыг онлайнаар өгдөг. Эхний шалгалт нь Оношлох шалгалтын үүргийг гүйцэтгэдэг. Оношлох шалгалтыг хичээлийн эхний өдөр авдаг. Дадлагын сүүлийн шалгалтыг сургалтын сүүлийн өдөр ангид өгдөг. Дадлагын сүүлийн шалгалт нь эцсийн шалгалт байдаг.

Хуваарь:

### **TOEFL I**

Өглөөний анги – 80 цаг 4 долоо хоног (өдөрт 4 цаг, долоо хоногт 5 өдөр)

Оройн анги – 72 цаг 4 долоо хоног (өдөрт 4.5 цаг, долоо хоногт 4 өдөр)

### **TOEFL II**

Өглөөний анги – 80 цаг 4 долоо хоног (өдөрт 4 цаг, долоо хоногт 5 өдөр)

Оройн анги – 72 цаг 4 долоо хоног (өдөрт 4.5 цаг, долоо хоногт 4 өдөр)

## **GMAT – Удирдлагын ур чадварын шалгах ерөнхий шалгалт**

72 цаг – ангид 54 хичээл, лабораторид 18 хичээл (4 долоо хоног, өдөрт 4.5 цаг)

(долоо хоногт 3 хичээл + 1 өдөр лабораторид)

## **GRE – Аспирант, магистрантуруудад зориулсан шалгалт**

72 цаг – ангид 54 хичээл, лабораторид 18 хичээл (4 долоо хоног, өдөрт 4.5 цаг)

(долоо хоногт 3 хичээл + 1 өдөр лабораторид)

## **SAT – Ерөнхий мэдлэгийн шалгалт**

48 цаг – ангид 36 хичээл, лабораторид 12 хичээл (4 долоо хоног, өдөрт 3 цаг)

(долоо хоногт 3 хичээл + 1 өдөр лабораторид)

Сургалтын төлбөр:

TOEFL	\$850 өглөөний анги - \$650 оройн анги	
SAT – Ерөнхий мэдлэгийн шалгалт		\$ 575
GRE – Аспирант, магистрантуруудад зориулсан шалгалт		\$1100
GMAT – Удирдлагын ур чадварын шалгах ерөнхий шалгалт		\$1200

## **ХФК сертификатын хөтөлбөрүүд**

### **Хөтөлбөрийн агуулга**

Ажил мэргэжилдээ өсөн дэвжихэд Англи хэлийг ашиглах нь даяарчлалын өнөө үед улам их ач холбогдолтой болж байна. Жижиг аж ахуйн нэгжээс авахуулаад олон улсын томоохон компаниуд, төрийн болон хуулийн байгууллага зэрэг бүх төрлийн албан байгууллагад ажиллаж буй мэргэжлийн хүмүүс хил даван, олон соёлтой төрөлжсэн нийгэмд харилцаж сурах ёстой. Англи хэлээр харилцах чадвартай байх нь тухайн хүн ажил мэргэжилдээ өсөн дэвжихтэй салшгүй холбоотой гэсэн үг юм. ХФК-ийн сертификатын хөтөлбөр нь сургалтанд хамрагдсаны ажил мэргэжилд шаардагдах хэлний чадварыг өгөхийг зорьдог.

Сургалтууд нь Англи хэлийг бодитоор, тодорхой зорилгоор хэрэглэхэд голлон анхаардаг.

ХФК нь Бизнесийн болон Хууль зүйн Англи хэлний сургалтуудыг мэргэжлийн хүмүүст зориулж тэдгээрийн тодорхой хэрэгцээнд нийцсэн өндөр чанартай, эрчимжүүлсэн хичээлийг санал болгодог. Хөтөлбөрт хамрагдсан хүмүүс Америкийн бизнесийн эсвэл хууль зүйн нэр томъёог үр дүнтэй ашиглаж харилцах чадвартай болдог.

Хичээлийн явцад оюутнуудтай харилцах харилцаа нь утга төгөлдөр харилцаанд тулгуурладаг бөгөөд оюутны хэлний чадварыг бодитоор хөгжүүлэхийг чухалчилдаг. Бид зөвхөн баталгаатай материал ашигладаг бөгөөд оюутнуудын мэргэжлийн чиглэлийн үр чадвар болон Англи хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор хичээлүүд маань оюутан төвтэй, оюутны оролцоотой байдаг. Багш нар маань аль болж өгөх ойр ойрхон бодит амьдралыг загварчилсан орчинд хичээлээ явуулдаг. Багш нар маань өндөр боловсролтой, арвин их туршлагатай, компани, хууль болон эмнэлгийн мэргэжлээр ажиллаж байсан хүмүүс байдаг.

Хичээл заахын зэрэгцээ ХФК нь зочдоор лекц уншуулж, сургалттай хамааралтай аялалуудыг зохион байгуулдаг. Хөтөлбөрийг амжилттай сурч дүүргэсний дараа оюутнуудад сертификат өгдөг. Энэ сертификат нь тухайн хүний мэргэжлийн чиглэлтэй холбоотой Англи хэлний нэр томъёо болон агуулгын бүрэн мэдлэгтэй болсны илэрхийлэл юм.

## **Бизнесийн Англи хэл**

Бизнесийн Англи хэлний сургалт нь оролцогчдыг сүлжээ үүсгэх, хэлэлцээр хийх, маргаан зөрчилдөөнийг шийдвэрлэх, уулзалтыг удирдан зохион байгуулах, илтгэл тавих, олон улсын багуудад зааварлах, телеконференц хийх болон албан ёсны урилга, албан тоот, албан ёсны и-мэйл, хураангуй, тайлан, санал, уулзалтаас гарсан авах арга хэмжээнүүд, санхүүгийн гүйцэтгэлийн хураангуй, зөвлөхийн гэрээ, албан байгууллагын үйл ажиллагааны ерөнхий үзэл баримтлал, ажлын зар гэх мэт бизнесийн бичиг баримт бичих зэрэгт сургаж бэлддэг.

Бизнесийн Англи хэлний лекцийн сэдвүүдэд олон улсын бизнес, олон нийтийн болон хувийн хэвшлийн салбар дахь түншлэлүүд, корпорацуудад үзүүлэх банкны үйлчилгээ, санхүү, АНУ-ын Холбооны нөөцийн тогтолцоо, хувийн хэвшлийн байгууллагыг өр төлбөрөөс чөлөөлөх ажиллагаа, зөвлөгөө өгөх, онлайн бизнес эрхлэх, хувиараа бизнес эрхлэх гэх мэт сэдвүүд багтана.

Бизнесийн Англи хэлний сургалтын аялалд Холбооны нөөцийн газар, АНУ-ын Зоос үйлдвэрлэгч байгууллага, АНУ-ын Патентын газар, янз бүрийн олон улсын корпорацын төв офисууд, үндэсний банкууд, орон нутагт шинээр үүсэн байгуулагдсан бизнесүүд зэрэг багтана.

Цаашилбал, НФС нь Бизнесийн Англи хэлний сургалтын хөтөлбөрийнхөө агуулгыг таны заасан шаардлагад нийцүүлж тохируулдаг. Бизнесийн Англи хэлний сургалтын хичээлийг олон тооны салбар болон сэдвийн хүрээнд сурталчилгаа, маркетинг, аялал жуулчлал, зочломтгой найрсаг зан байдал, улс төр, хувийн хэвшлийн салбар, гадаад харилцаа, олон улсын худалдаа, импорт, экспорт, хүний нөөц зэрэг сэдэв чиглэлүүд орно.

## **Хууль зүйн Англи хэл**

Хууль зүйн Англи хэлний сургалт нь оролцогчдод Англи хэлээр ярьдаг үйлчлүүлэгчдийнхээ төлөөлөл болох, гэрээ хэлцэл байгуулах, албан тоот болон бусад хууль зүйн бичиг баримтыг бичгэн хэлбэрээр үйлдэх, шүүх ажиллагааг Англи хэл дээр явуулах, хууль зүйн хам сэдвээр ярианы чадвараа сайжруулах зэргийг зааж сургана.

Хууль зүйн Англи хэлний лекцийн сэдвүүдэд Америкийн Нэгдсэн Улсын шүүх засаглалын тогтолцоо, Дээд шүүх, хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, хууль зүйн боловсролын тогтолцоо, иргэний журам, гэмт этгээдийг шилжүүлж өгөх тухай хууль зэрэг багтана.

Хууль зүйн Англи хэлний сургалтын аялалд Цагаан ордон, Пентагон, Холбооны мөрдөх товчоо, АНУ-ын Конгрессийн ордон, Төрийн Департамент, Дээд шүүх, холбооны эсвэл улсын шүүх байгууллагууд, цагдаагийн байгууллагууд, хуулийн байгууллагууд, Жорж Вашингтоны нэрэмжит их сургууль, Жоржтауны их сургууль, АНУ-ын сенаторууд эсвэл төлөөлөгчидтэй хийх уулзалтууд орно.

Цаашилбал, ХФК нь Хууль зүйн Англи хэлний сургалтын хөтөлбөрийнхөө агуулгыг таны заасан шаардлагад нийцүүлж тохируулдаг. Хууль зүйн Англи хэлний сургалтын хичээлүүдийг олон улсын худалдааны тухай хууль, цагаачлалын хууль, бүтээгдэхүүний хариуцлагын тухай хууль, олон улсын өмч хөрөнгийн тухай хууль, корпорацын санхүүгийн тухай хууль, үндэсний аюулгүй байдал ба эрүүгийн хууль гэх мэт олон тооны салбар, сэдэвт нийцүүлэх боломжтой.

## Эмнэлгийн Англи хэл

Эмнэлгийн Англи хэлний сургалт нь оролцогчдыг өвчтөнтэй олон төрлийн эрүүл мэндийн асуудал, тэдгээрийн холбогдох шинж тэмдгүүд, шалтгаанууд болон авах боломжтой эмчилгээний талаар харьцаж ярилцахад бэлтгэж өгнө. Мөн, оролцогчдыг хамтран ажиллагч эмнэлгийн ажилтнуудтай харилцах, өвчтөний түүх, эмнэлэг ба эмчилгээний талаархи өгүүлэл, тухайн өвчтөний талаар бусад эмнэлгийн мэргэжилтнүүдтэй харьцсан захидал, албан тоот гэх мэт эмнэлгийн бичиг баримтыг мэргэжлийн түвшинд бичиж сурахад бэлтгэдэг.

Эмнэлгийн Англи хэлний лекцийн сэдвүүдэд АНУ-ын Эрүүл мэнд, хүний үйлчилгээний департаментын үйл ажиллагаа, АНУ-ын эрүүл мэндийн тогтолцоог тойрсон маргаан ба зөрчилдөөн, АНУ дахь эрүүлийг хамгаалах хувийн байгууллага, улсын эмнэлгийн үйлчилгээ, үнэ төлбөргүй эмчилгээ, АНУ-ын эмчилгээний судалгаа гэх мэт сэдвүүд орно.

Эмнэлгийн Англи хэлний сургалтын аялалд Жорж Вашингтоны нэрэмжит их сургууль, Жоржтауны их сургууль зэрэг сургуулиудын дэргэдэх клиник эмнэлгүүд, Үндэсний эрүүл мэндийн институт, Хүүхдийн судалгааны институт, Вашингтон хотын хорт хавдрын институт, Арлингтоны үнэгүй клиник эмнэлэг ба бусад маршрут багтана.

Цаашилбал, ХФК нь Эмнэлгийн Англи хэлний сургалтын хөтөлбөрийнхөө агуулгыг таны заасан шаардлагад нийцүүлж тохируулдаг. Эмнэлгийн Англи хэлний сургалтын хичээлийг кардиолог, невролог, эх барихуйн ухаан/гинекологи, хүүхдийн эмнэл зүй, рентгэн зураг авалт, өвчтөний асаргаа, эмнэлгийн байгууллагын удирдлага гэх мэт олон тооны салбар, сэдэвт тохируулах боломжтой.

Сургалтын үргэлжлэх хугацаа: 4 долоо хоног

Хичээлийн цаг: Даваа-Баасан гаригуудад 9:00-12:00 цагийн хооронд

Сургалтын төлбөр: Бизнесийн Англи хэлний сертификатын хөтөлбөр -	\$3400
Хууль зүйн Англи хэлний сертификатын хөтөлбөр -	\$3500
Эмнэлгийн Англи хэлний сертификатын хөтөлбөр -	\$4350

## **Зуны сургуулийн хөтөлбөр**

Харриет Фулбрайт Коллежийн зуны сургуулийн хөтөлбөр нь Англи хэл сурахын хажуугаар Вашингтон хотод адал явдлаар дүүрэн аялах боломжийг олгодог. Оюутнууд Англи хэлний эрчимжүүлсэн сургалтын хичээлдээ өглөөний цагаар суугаад, үдээс хойш аялал хийж, Англи хэл дээр дадлага хийж, манай улсын нийслэл хотыг судалж танилцдаг. Аялалд Вашингтон (Колумбийн тойрог) хотын музей, цэцэрлэгт хүрээлэн, үндэсний хөшөө дурсгалууд, АНУ-ын Конгрессын ордон, Цагаан ордон, Холбооны мөрдөх товчоо болон бусад газрууд багтана.

Жинхэнэ Америк дадлага туршлага олж авах үүднээс оюутнууд хүлээн авагч гэр бүлтэй хамт амьдарч болдог. Хүлээн авагч гэр бүлтэй хамт амьдрах нь Вашингтон хотод сурахын хажуугаар гэрийн дотно орчинд байх сайхан боломж юм. Мөн, оюутныг зөвхөн Англи хэл дээр харьцдаг орчинд байлгах хамгийн шилдэг арга юм. Хүлээн авагч гэр бүл нь тусдаа унтлагын өрөө (нэг хүний ор, хувцасны шүүгээ, ширээтэй), ор дэвсгэрийн даавуу, саван гоо сайхны хэрэгсэл, өдрийн хоёр хоол, нийтийн унаанд суух билет зэргээр хангах болно.

16-аас дээш насны оюутнууд ХФК-ийн эзэмшлийн орон сууцны байранд амьдрахыг илүүд үзэж магадгүй. Сургуулийн ойролцоо хоёр өөр байрлалд байдаг ХФК-ийн эзэмшлийн орон сууц нь үзэсгэлэнтэй бөгөөд эрч хүчээр дүүрэн орчинд байдаг. Байрнаас нийтийн тээврийн хэрэгсэлд хүрч очих амархан бөгөөд хэрэглээний бүх зардал (нийтийн үйлчилгээ, кабелийн телевиз, интернет, тавилга) заасан үнэд орсон болно. Нэг байранд дөрвөн оюутан байрлах бөгөөд байр тус бүр хоёр унтлагын өрөөтэй.

Сургалтын үргэлжлэх хугацаа: 4 долоо хоног

Хичээлийн цаг: Даваа-Баасан гаригуудад 9:00-18:00 цагийн хооронд

Сургалтын төлбөр: \$850

Арга хэмжээний төлбөр:

ХФК-ийн эзэмшлийн орон сууц: \$750

Хүлээн авагч гэр бүлд амьдрах: \$850 - \$1400